



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн санхүүжилтээр барьж ашиглалтад оруулсан, нийт 278,367,568.00 (хоёр зуун далан найман сая гурван зуун жаран долоон мянга таван зуун жаран найм) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Уул уурхайн 09 дүгээр ангид эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Уул уурхайн 09 дүгээр ангийн захирагч, хурандаа Д.Гантулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.2 Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2025 оны 02 дугаар сарын 20 ны өдрийн  
88 дугаар тогтоолын хавсралт

УУЛ УУРХАЙН 09 ДҮГЭЭР АНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| д/д      | Хөрөнгийн нэр, байршил                                                  | Ашиглалтад орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Хөрөнгийн үнэ (төгрөг)                                                                                             |
|----------|-------------------------------------------------------------------------|---------------------|-------------|------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1        | Сургалтын далд уурхай /Налайх дүүрэг 8-р хороо Уурхайчин гудамж/        | 2024                | м2          | 181.4      | 272,800,268.00                                                                                                     |
| 2        | Төхөөрөмж /Өндрөөс аврах ажиллагааны дадлага сургуулилтын төмөр цамхаг/ | 2024                | ш           | 1          | 1,440,100.00                                                                                                       |
| 3        | Төхөөрөмж /сүлжээ ороомог/                                              | 2024                | ш           | 1          | 1,013,460.00                                                                                                       |
| 4        | Төхөөрөмж /тэмээ шат/                                                   | 2024                | ш           | 1          | 980,520.00                                                                                                         |
| 5        | Төхөөрөмж /дадлагын/                                                    | 2024                | ш           | 1          | 1,670,190.00                                                                                                       |
| 6        | Төхөөрөмж /дүүжин савлуур/                                              | 2024                | ш           | 1          | 463,030.00                                                                                                         |
| Нийт дүн |                                                                         |                     |             |            | 278,367,568.00<br>(хоёр зуун далан<br>найман сая гурван<br>зуун жаран<br>долоон мянга<br>таван зуун жаран<br>найм) |